



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024. 01. 17 № А-1/88
танай _____-ны № _____-г

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр зарласан МОХИУАӨДЗЧНЭМСНТ/202301002 дугаартай "6 сав газрын менежментийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт; эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан шинэчлэх /шинэчлэн боловсруулж батлуулах" төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

Тодруулга	Хариулт
Тендерийн бичиг баримтанд тусгагдсан ТӨЗ 3.5 "Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа: Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байна." гэж заасан нь цахим тендерийн хүлээн авах хугацаа буюу 1 сарын 26-ны өдрөөс хойш 28 хоногоор тооцох эсэх.	Тендерийн хүчинтэй байх хугацаа нь тендерийн нээлт хийснээс хойш 30 хоногт хүчинтэй байх бөгөөд тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байна.
Урилга дээр "Энэхүү урилгыг хүлээн авсан тухайгаа албан ёсоор манай байгууллагад мэдэгдэнэ үү." гэдэг нь цаасан албан бичгээр заавал хариу мэдэгдэх гэсэн утгатай эсэх.	Ирүүлэх шаардлагагүй.
"Тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх" гэдэг нь гэрээт ажилтнуудтай хамааралтай эсэх.	Хамааралтай.
ТӨЗ 5.6 "Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендер оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр" гэсэн өдрийг цахим тендерийн сайт дээрх 01 дүгээр сарын 26-ны өдрөөр тооцох эсэх.	Санал хүлээн авах эцсийн хугацаа 2024 оны 01 дүгээр сарын 26 -ны өдрийн 11 цаг 40 минутаас өмнө ирүүлсэн байх ба 2024 оны 01 дүгээр сарын 26 -ны өдрийн 11 цаг 50 минутад саналыг нээнэ.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1324020275